



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 09 сарын 24 өдөр

Дугаар А/184

Улаанбаатар хот

Багахангай дүүргийг орон нутгийн
зэрэглэлтэй хот болгон хөгжүүлэх бэлтгэл
ажлыг хангах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.7 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.5 дахь заалт, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны А/06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Багахангай дүүргийг орон нутгийн зэрэглэлтэй хот болгон хөгжүүлэх бэлтгэл ажлын хүрээнд 2024 оны 09 дүгээр сарын 24-ний өдөр дүүрэгт гадаадын зочид төлөөлөгчдийг хүлээн авч, орон нутгийн өнөөгийн нөхцөл байдал, хөгжлийн хөтөлбөр, төлөвлөлт, ирээдүйн чиг хандлага, онцлог, давуу талыг танилцуулж ажиллахыг Засаг даргын Тамгын газар (Л.Санжийжамц)-т үүрэг болгосугай.

2.Арга хэмжээ зохион байгуулах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, зарцуулагдах хөрөнгийн төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Шаардагдах 3,810,000 (Гурван сая найман зуун арван мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй .


4.Арга хэмжээний бэлтгэл ажлыг сайтар хангаж, зохион байгуулалтын өндөр түвшинд, чанар, үр дүнтэй зохион байгуулж, ажлын хэсгийн гишүүдийг удирдлага, арга зүйгээр хангаж, хяналт тавьж, ажиллахыг Ажлын хэсэг (Б.Болормаа)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2024 оны 09 сарын 24-ны өдрийн 118 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙГ ОРОН НУТГИЙН ЗЭРЭГЛЭЛТЭЙ ХОТ
БОЛГОН ХӨГЖҮҮЛЭХ БЭЛТГЭЛ АЖЛЫГ ХАНГАХ
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга: Гишүүд:	Б.Болормаа	Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч
	Г.Дагвадорж	Дүүргийн менежер
	Л.Санжийжамц	Засаг даргын Тамгын газрын дарга
	Д.Эрдэнэтуяа	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зохион байгуулалтын хэлтсийн дарга (зөвшилдсөнөөр)
	Ц.Мягмарсүрэн	Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
	Б.Цогжавхлан	Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга
	Д.Хүрэлбаатар	Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга
Нарийн бичиг:	Н.Нямзав	1 дүгээр хорооны Засаг дарга
	Б.Батзориг	2 дугаар хорооны Засаг дарга
	Т.Лхагвасүрэн	Цагдаагийн хэлтсийн дарга, хурандаа
	Г.Гомбо	Багахангай Үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ-ын захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
	Б.Отгонжаргал	Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2024 оны 09 сарын 07-ны өдрийн 113 дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙГ ОРОН НУТГИЙН ЗЭРЭГЛЭЛТЭЙ ХОТ
БОЛГОН ХӨГЖҮҮЛЭХ БЭЛТГЭЛ АЖЛЫН ТӨСӨВ

№	Бараа материалын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Үнэ
1.	Цэвэр ус	ш	200	1800	360,000
2.	Цай, кофе	ш	120	1500	180,000
3.	Бургер	ш	60	8000	480,000
4.	Өдрийн хоол	ш	60	24500	1,470,000
5.	Дэвтэр	ш	60	12000	720,000
6.	Бал	ш	60	2000	120,000
7.	Гарын авлага	ш	60	8000	480,000
Дүн					3,810,000